

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2015 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх ажил/арга хэмжээ		Биелэлт
1.	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулж батлуулах	Шийдвэрийн төслийг сонирхогч бүлэг, олон нийтээр хэлэлцүүлэх /веб хуудсаар/	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийн анхан шатны боловсруулалтыг хийж, 2014 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Монголын Эрчим хүч – 2014” олон улсын хуралдаан дээр танилцуулсан. Салбарын эрдэмтэд, инженер техникийн ажилтнууд, судлаачид болон олон нийтээс санал авах зорилгоор 2014 оны 06 дугаар сарын дунд 10 хоногт Эрчим хүчний яамны цахим хуудсанд төслийг бүрэн эхээр нь тавьсан, нийт 5 удаагийн хэлэлцүүлгийг хийж санал авсан. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичгийг төслийг эцэслэн боловсруулж Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт ЗГХЭГ-т хүргүүлж Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 13-ны хуралдаанаар хэлэлцүүлж хуралдаанаас баримт бичгийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Бодлогын баримт бичгийн төслийг холбогдох тогтоолын хамт УИХ-ын эдийн засгийн байнгын хорооноос томилсон ажлын хэсэгт шилжүүлж, ажлын хэсэг ажилласан. 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэн батлагдсан.
2.		Сонирхогч бүлэг олон нийтийн саналыг тусгах /саналын товчоо, хэрхэн тусгасан байдал/	
3.	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-т хүргүүлэх	Эрчим хүчний сайдын 2015 оны 02 дүгээр сарын 16-ны өдрийн 41 тоот тушаалаар “Эрчим хүчний яамны 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. Төлөвлөгөөний төсөлд Авлигатай тэмцэх газраас саналыг цахимаар авч тусгасан болно. 2015 оны яамны авилигийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 76 ажил арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Эдгээр ажлууд нь төлөвлөгөөт хугацаанд хэрэгжиж байна.
4.		Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах /хэрэгжилтийг бүрэн тайлагнах/	Төлөвлөгөөний хэрэгжилтийг цаг тухай бүр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.
5.		Тайлан, нотлох баримтыг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх	Хэрэгжилтийн тайланг 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр АТГ-т Эрчим хүчний яамны ТНБД-ын тоот албан бичгээр хүргүүлэв.

6.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар ажилтнуудад танилцуулга хийх	Төрийн албан хаагчдад хөрөнгө орлогын мэдүүлэгийг үнэн зөв, шудрагаар бөглөх талаар АТГ-ын холбогдох мэргэжилтнийг урьж сургалт, ярилцлага хийж зөвлөгөө авсан. ЭБАТ зүгээс яамны аппаратын ажиллагсадын дунд авлигаас урьчилан сэргийлэх, сонирхолын зөрчлийн талаар мэдээллийн цагаар сургалт зохион байгуулсан.
7.		Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, яриа таниулга, теле сурталчилгаа, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал гм/	Авлигын эсрэг хууль тогтоомжийг өөрийн яамны цахим хуудасны “Авлигын эсрэг хамтдаа” булангийн хууль эрх зүйн актууд буланд байршуулсан. Мөн АТГ-аас гаргасан сурталчилгааны хэвлэмэл материалуудыг яамны албан хаагчдад тарааж танилцуулах сургалт зохион байгуулсан.
8.		Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллагад түгээн ажилласан байх	
9.	Салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах	Жагсаалт гаргаж АТГ-т хүргүүлэх /хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх дүрэм, журмыг нэрээр нь байршуулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх/	Эрчим хүчний салбат хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм журамын жагсаалтыг гаргаж АТГ-т хүргүүлсэн. Мөн өөрийн яамны цахим хуудасны хууль эрх зүй буланд байршуулсан.
10.	Шинээр боловсруулж буй хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийт, сонирхогч бүлгээр хэлэлцүүлэх, тэдний саналыг тусгах	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх	Эрчим хүчний яамны цахим хуудасны Хэлэлцүүлэг булангаар дамжуулан 2015 онд нийт 15 хууль тогтоомж, дүрэм журмуудын төслийг байршуулж иргэд, олон нийтээс санал авах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн төсөлд иргэд олон нийтээс санал авахаар цахим хуудсанд байршуулсан. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд иргэд олон нийт,
11.		Эдгээр төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлсэн байх	

12.		Саналыг хэрхэн тусгасныг тайлагнах	салбарын үйлдвэр компаниудаас яамны цахим хуудсын хэлэлцүүлэг буланд тавьж санал авч холбогдох саналуудыг тусгасан.
13.	ЭХЯ-наас гадагш чиглэсэн хяналт шалгалт /хаана, ямар хяналт шалгалт хэрэгжүүлэх тухай нэрээр дурдаж бичих/	Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байдал	Эрчим хүчний яамны 2015 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг яамны цахим хуудсанд байршуулсан. Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн даргын хооронд байгуулах Үр дүнгийн гэрээнд яамнаас 2015 онд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөсөн.Яамны төлөвлөгөөнөөс холбогдох хэсгийг тусгайлан авч цахим хуудасны “Хууль тогтоомж” гэсэн нүүр хуудасны “Дотоод аудит” гэсэн хавтсанд байршуулав. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаар яамны цахим хуудсан тавьсан.
14.		Хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээний нээлттэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ	
15.		Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ	
16.	Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг веб сайтад байршуулах	ЭХЯ-ны 2015 оны төсөв	2015 оны яамны төсвийг яамны цахим хуудсанд байршуулсан.
17.		2014 оны төсвийн гүйцэтгэл	2014 оны төсвийн гүйцэтгэлийг “Energy.gov.mn” цахим хуудсанд 2015 оны 3-р сард мэдээлсэн
18.		2016 оны төсвийн төсөл	Эрчим хүчний сайдын багцын 2016 оны төсвийн төслийг яамны цахим хуудсын “Ил тод байдал”-ын “Төсөв санхүүгийн ил тод байдал” цэсэнд байршуулсан.
		2014 оны санхүүгийн тайлан	2014 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланг Energy.gov.mn, Ил тод байдлын самбарт мэдээлсэн
19.	2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		
20.		2015 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл	“Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг яамны цахим хуудсын “Ил тод байдал”-ын “Төсөв санхүүгийн ил тод байдал” цэсэнд байршуулсан.

21.		талаарх 2014 оны мэдээлэл /татварын, татварын бус/Төсвийн орлого бүрдүүлэлтийн	Эрчим хүчний яаманд татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт байхгүй.
22.		Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний талаарх мэдээлэл	Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт
23.		2015 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг вебсайтад байршуулах	2015 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг вебсайтад байршуулах
24.		2015 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр жагсаалтыг гаргаж АТГ-д ирүүлэх	Эрчим хүчний салбарт гадаадын зээл тусламжээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг яамны цахим хуудасны төсөл хөтөлбөр буланд байршуулсан.
25.		Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг вебсайтад байршуулах	
26.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжийг хангах	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гм бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн	Тус яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл техникийн нөхцлийн талаар цахим хуудсандаа “Зөвшөөрөл” гэсэн үндсэн цэсэнд байршуулсан. Тусгай зөвшөөрөл олгох журам, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, цахилгаан дулааны техникийн нөхцөл олгох журам, холбоо барих мэргэжилтэнгүүдийн ажлын утасны жагсаалт зэргийг цахим хуудасны “Зөвшөөрөл” үндсэн цэсэнд байршуулсан. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан даруйд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон огноо, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа зэрэг мэдээллийг агуулсан мэдээллийг цахим хуудасны Тусгай зөвшөөрөл булангийн Тусгай зөвшөөрөл эзэмшигчид цэсэнд байршуулж байна.
27.		жагсаалтын гаргах, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг цахим хуудас, мэдээллийн самбарт нээлттэй байршуулсан байх	
28.		Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болгох хугацааг цахим хуудсанд байршуулсан байх	
29.		Хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүдийн мэдээллийг ил тод, нээлттэйгээр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байх	

30.	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Яамны цахим хуудсанд Ил тод байдал цэсэнд “Сул ажлын байрны зар” нэртэй тусгайлсан цэс ажиллуулж байна. 2015 онд тус яаманд сул ажлын байр гараагүй болно.
31.		Сонгон шалгаруулалт явуулах талаар цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	
32.		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлэх үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах	
33.	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах	Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж АТГ-д ирүүлэх	Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж АТГ-т хүргүүлсэн
34.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөн-гөөр бараа ажил ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, веб сайтад байршуулах	Худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг хуулийн хугацаанд өөрийн цахим хуудасны Шилэн данс цэсэнд байршуулсан.
35.		Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг ил тод мэдээлэх	Тухайн төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг болон урилгыг тухай бүр өөрийн цахим хуудас болон Сангийн яамны www.mof.gov.mn сайтуудад байршуулсан.
36.			
37.		Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг танилцуулах	Шилэн дансны нэгдсэн болон Яамны цахим хуудасны шилэн данс цэсэнд “Тендер шалгаруулалт 2015” нэртэйгээр байршуулсан. Мөн тендер шалгаруулалтын үр дүнг өөрийн цахим хуудас болон Сангийн яамны www.mof.gov.mn сайтуудад байршуулсан.

38.		Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд байршуулсан байх	Шилэн дансны нэгдсэн сайт болон өөрийн яамны цахим хуудасны шилэн данс цэсэнд байршуулсан.
39.		Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчилгүй болно.
40.		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх	Эрчим хүчний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны худалдан авах ажиллагааны тайланд хийсэн Сангийн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 2-ны 6/1760 албан бичгээр ирүүлсэн үнэлгээний тайланг цахим хуудасны шилэн данс цэсэнд байршуулсан
		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Тус яамнаас зарлагдсан тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд “Эрчим хүчний ассоиаци” ТББ, Эрчим хүчний угсралт засварчдын холбоодын 2-оос доошгүй төлөөллийг оролцуулсан.
41.		Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	Худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг хуулийн хугацаанд өөрийн цахим хуудасны Шилэн данс цэсэнд байршуулсан.
42.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлсэн байх	Засгийн газрын 2014 оны 402 дугаар тогтоолоор яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан. Үүний дагуу яамны нийт ажлын байрны тодорхойлолтыг батлаж мөрдөн ажиллаж байна.

		Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх	Яамны цахим хуудсанд “Яамны тухай” гэсэн нүүр хуудасны “Газар хэлтэс” хавтас доторх газар хэлстийн танилцуулгад нийт албан хаагчдын нэр, албан тушаал, хариуцсан ажил үүрэг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэргийг байршуулсан.
43.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөний дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	Сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн зарим үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх /ямар арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх талаар тодорхой тусгах/	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, сайн дурын үйл ажиллагаан оролцоогүй болно.
44.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Дүрмийн төслийг боловсруулж АТГ-аас санал авах	АТГ-ын зөвлөмжийн дагуу яамны ёс зүйн дүрэмд тусгасан. Ёс зүйн дүрмийг батлаж мөрдүүлэн ажиллаж байна.
45.		Дүрмийг батлах, нийт албан хаагчдад танилцуулах	
46.		Хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаар АТГ-т тайлагнах	
47.		Зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, зөрчлийг шийдвэрлэх, хариуцлага тооцох, зөрчлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах, хамт олонд мэдээлэх	Яамны байранд зөрчлийн талаарх саналын хайрцаг мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.
48.		Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргах	2015 онд Авлигатай тэмцэх газрын ажилтныг урьж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар яамны мэдээллийн цагаар нийт албан хаагчдад мэдээлэл хийлгэв. Энэ хүрээнд хууль тогтоомжоор зөвшөөрсөн давхар ажил эрхлэлттэй холбогдох мэдээллийг албан хаагчдад танилцуулсан болно. Тус яаманд албан хаагчдад давхар ажил эрхлэлттэй холбоотой асуудал гараагүй болно.
49.		Давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах	
50.		Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг цахим хуудсанд байршуулах	Эрчим хүчний сайд, ТНБД-аас гарч буй ажил хэргийн холбогдолтой тушаалыг яамны цахим хуудасны Хууль эрх зүйн сан буланд байршуулах ажлыг тогтмол хийж байна.

51.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын жагсаалтыг гаргаж ТНБД-аар батлуулан Авлигын эсрэг хамтдаа булангийн Хууль тогтоомж цэсэнд байршуулсан.
52.		Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	
53.		Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах	
54.	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээлэх		Эрчим хүчний яаманд 2015 онд Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал гараагүй болно.
55.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмж	Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас зөвлөмж, шийдвэр ирээгүй болно.
56.		АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар албан бичиг ирүүлээгүй болно.
57.		Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичиг	Тус газраас “Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгуулах тухай” 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр 01/4252 тоот албан бичгийн хариуг 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн в/2288 тоот албан бичгээр холбогдох материалын хамт хүргүүлсэн.
58.		Хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичиг	АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичиг ирээгүй болно.
59.		Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тус газраас тайлант хугацаанд авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгуулахаар албан бичгийг ирүүлээгүй болно.

60.		АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын хэрэгжилт	Журмыг яамны цахим хуудсанд байршуулав.
61.	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол хүсэлтийг хүлээн авах шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх газар, хэлтсүүдийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрийг яамны цахим хуудсанд “яамны тухай” цэсэнд байршуулсан.
62.		Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар гм/	Яамны цахим хуудсанд “Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдол” гэсэн цэс нээж, түүгээр дамжуулан иргэд олон нийтээс өргөдөл гомдлыг авч хуулийн хугацаанд барагдуулан ажиллаж байна. Мөн Засгийн газрын 11-11 төвөөр дамжиж тус яаманд цахимаар ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна.
63.		Үйлчилгээ, захидал харилцаа хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Өргөдөл гомдол, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, ажлын утас, Эрчим хүчний яамны албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам зэргийг яамны цахим хуудасны “Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдол” цэсэнд байршуулсан.
		Бусад этгээдээс шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн талаар цахим хуудсаар мэдээлэх Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх	Эрчим хүчний яаманд 2015 оны хагас жилийн байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын тухай тайланг “Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдол” цэсэнд байршуулсан.
65.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэх эрмэлзлэл, хүчин чармайлт, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	Авилагын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх	Шилэн дансны хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан яамны цахим мэдээллийн самбар, мэдрэгчтэй дэлгэц авахад зориулан 4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.
66.		Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар арга	Албан хаагчдын хоол унааны мөнгийг нэмэгдүүлж олгож байгаа.

		хэмжээ авах	
67.		Эрх бүхий албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах	Эрх бүхий албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна.
68.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлтийг хангуулах	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар албан бичиг ирүүлээгүй болно.
69.		Авлигатай тэмцэх газраас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хангуулах	Тус газраас “Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгуулах тухай” 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр 01/4252 тоот албан бичгийн хариуг 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн в/2288 тоот албан бичгээр холбогдох материалын хамт хүргүүлсэн.
70.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тус газраас тайлант хугацаанд авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгуулахаар албан бичгийг ирүүлээгүй болно. Журмыг яамны цахим хуудсанд байршуулав.
71.		Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлтийг хангуулж ажиллах	

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ